

Алтайн урианхайн харвах наадгай

Тогтохын Эрдэнэтуяа

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Бат-Өлзийн Баатархүү 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс

 baatarkhuu.huum@gmail.com

Хураангуй. Алтайн урианхайн долоон хошууны ард түмэнд уламжлагдан ирсэн “Урианхай сурын харваа”, “Шагайн харваа” зэрэг харвах төрлийн наадгайн талаар өгүүлэв. Монголчуудын сурын харвааны нэгэн төрөл болох “Урианхай сурын харваа” нь зөвхөн Алтайн урианхайн долоон хошууны хойч үе болох монгол урианхай болон тува урианхайчуудын дунд уламжлагдан ирсэн өвөрмөц онцлогтой бөгөөд тэд үүнийгээ Чингис хааны түүхэн үйл явдалтай холбон домоглон ярьдаг. Мөн Алтайн монгол урианхай болон тува урианхайчуудын дунд шагайн харвааны нэгэн өвөрмөц төрөл болох “Зээр харваа” уламжлагдсан байна. Энэхүү өгүүлэлд дээр өгүүлсэн харвах наадгайн түүхэн уламжлал, өвөрмөц онцлогийн талаар өгүүлэхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: *харвах наадгай, урианхай сур, шагайн харваа, зээр харваа, нуман тамга*

Shooting sports by Uriankhai people in Altai

Erdenetuya Togtokh

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Baatarkhuu Bat-ulzii 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

 baatarkhuu.huum@gmail.com

Abstract: Shooting sports as Uriankhai archery”, “Shagain harvaa (Sheep ankle bone target shooting)” inherited by Uriankhai people in seven khoshun, Altai mountain ranges are considered here. “Uriankhai archery”, one of the unusual Mongolian archery ways has inherited only by Mongolian Uriankhai and Tuva Uriankhai people who are the

descendants in seven Uriankhai hoshuns, Altai mountain ranges. Uriankhai people have many legends connected with their archers participation Chinggis khan's historical events. Moreover, "Antelope shooting", a special Shagain harvaa has inherited by Mongolian and Tuva Uriankhai people in Altai mountain ranges. The historical inheriting ways and special features of abovementioned shooting sports are considered in the article.

Key words: *shooting sport, Uriankhai archery, shagain harvaa, Antelope harvaa, bow brand*

Оршил

Манжийн эрхшээлийн үеэс Алтайн урианхайн долоон хошуу гэж байсан бөгөөд үүний дөрөв нь монгол урианхай, гурав нь тува урианхайчууд байв. Өөрөөр хэлбэл, XIII зууны үеэс Алтайн уулаар оршин аж төрж ирсэн монгол урианхай болон тувачууд нь "Алтайн урианхай" хэмээх нэгэн засаг захиргаанд хамт оршиж ирсэн байна. Тиймээс Алтайн урианхайн долоон хошууны (монгол урианхай, тува урианхай) ард түмэнд уламжлагдан ирсэн "Урианхайн сурын харваа", "Шагайн харваа"-ны тухай өгүүлэв.

Судалгааны арга зүй

Алтайн урианхай, тувачуудын дунд явуулсан угсаатны зүйн хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүнийг гол эх сурвалж болгон, түүхэн зүйн зарчмыг баримтлан, түүхэн баримтыг нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх болон түүхэн харьцуулалтын аргыг гол болгов.

Судалгааны үр дүн

Шагайн харваа. Шагайн харваа нь Монгол угсааны олон бүлгүүдэд түгээмэл тархацтай тоглоомын нэг юм. Гэхдээ монголчууд нэгэн хэв загвараар бус газар нутаг, угсааны бүлгүүд бүр өөр өөрийн харвааны дэг, уламжлалтай.

Монголчууд ганзганаасаа хэтэрсэн болон сүргийн манлай анг агнахыг цээрлэдэг. Магнай анг агнавал уг сүрэг зүг чиг, зохион байгуулалтаа алддаг байна. Гөрөөс гурваас дээш бол нэг сүрэгт тооцогддог тул гурван гөрөөс тааралдвал нэгээс хоёрыг нь агнаж, нэгийг заавал үлдээдэг. Бас олон гөрөөс дотор ганц эр гөрөөс байвал агнадаггүй. Учир нь сүргийн өсөлт, тоо толгойд сөргөөр нөлөөлнө гэж үздэг.


Ойрад монголчууд сүргийн магнай анг "цэгц", "бөг", "тэвш" гэх зэргээр нэрлэнэ. Шинжааны торгууд, хошуудууд магнай анг "дүүв", "дүүвэр", "туужаа" гэхчилэн нэрлэдэг. Манлай анг ан амьтны амьдралд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг гэдгийг Алтайн тува урианхайчууд болон Алтайн монгол урианхайчуудын шагайн харваанаас тодорхой харж болох юм (Баатархүү 2017, 317). Уг шагай харваа нь харьцангуй эртний уламжлалаа хадгалсан төдийгүй ан авын зарим шүтлэг, зан үйлийг хадгалан үлдсэн байна.

Алтайн урианхайчууд шагайг харвахдаа тусгай хашлага хэрэглэхгүй, гэр дотор гэрийн баруун талд 6 м орчим зайнд хоёр талаас нь ээлжлэн шагайг шагайгаар харвадаг. Харвах шагайг тавих тусгай суурьтай самбарыг "зурхай" гэж нэрлэдэг. Зурхай нь энд шагайн талбай гэсэн утга агуулна. Алтайн урианхайчууд сур

харвахдаа сурын талбайг бас зурхай хэмээнэ. Шагайн зурхайн урт нь 60 см, өргөн нь 40-50 см, өндөр нь 40 см орчим ар тал нь эгц, өмнө тал нь налуудуу намхан байна. Харвахдаа хоёр тоглогч эсвэл хоёр багийн гишүүд бие биенийхээ өөдөөс харж суугаад хоёр талаас харвах тул зурхай, шагайгаа тус бүрдээ бэлтгэж авч ирнэ. Харвааны гол дунд хоёр зурхай тавина гэсэн үг. Зурхайг нийлүүлээд тавьчихвал харвах явцад аль нэг талынхаа шагайг унагаж болзошгүй тул хооронд нь зайтай тавьж байрлуулна. Харваач шагай харвахдаа аль нэгэн хөлөө дороо хийж нөгөө хөлийнхөө өвдгөө нугалж суугаад тэр хөлийнхөө өвдөг дээр зүүн эсвэл баруун гарынхаа алгыг дээш харуулж тавиад дээр нь сум шагайгаа тавьж харвана. Сум шагай нь арай томхон байвал сайн гэнэ. Янгирын шагайгаар сум хийж ирсэн уламжлал байдаг нь нэг талаас харвахад хөнгөвтөр хол явдаг нөгөө талаас ангийн шагай тул ончтой байна гэж бэлгэшээдэгтэй холбоотой. Харваач тоглолтонд таван сумтай оролцоно. Өөр хүнд сум дамжуулахыг цээрлэнэ. Сумаа бэлтгэж ирээгүй харваач тэр удаад тоглолтонд оролцох эрхгүй байдаг. Шагай харваачид хаа ч явсан өөрийн засаж цэвэрлэсэн, онч мэргийг нь тааруулсан таван сумаа авч явдаг. Харваа таарсан газар сумаа гарган тоглох учиртай. Алтайн урианхайн сурын харваанд хүн бүр хоёр чихтэй байдаг шиг шагайн харваанд хүн бүр таван сумаа авч ирэх ёстой. Харвах ээлжиндээ харваач таван сумаа дараалан харвана.


Шагайн харваа нь дотроо “Зээр харваа”, “Долоон галз харваа”, “Багц харваа” гэсэн гурван төрөлтэй байна (Ганболд, Эрдэнэтуяа 2019, 73-77).

“Зээр харваа”-ны дэг. Зурхай дээр долоон шагайг цувруулан нэг эгнээнд оруулан тавина. Ингэхдээ нэг шагайг голд хонь байдлаар хэвтүүлэн тавина. Үүнийг “бөг” гэнэ. Алтайн урианхайчуудын ан амьтны цэгцийг буюу ахлагчийг нь бөг гэж нэрлэдэг. Үлдсэн зургаан шагайг бөгийн хоёр талаар гурав гурваар нь тэмээ босгон эгнүүлэн тавина (Зураг 1). Энэ зургаан шагайг нийтэд нь “зээр” гэдэг. Тиймээс зурхай дээрх долоон шагай нь нэг цэгц ахлагчтай сүрэг ан амьтан болж байдаг.



Зураг 1. Зээр харвааны өрөг

Шагайн харваа нь үүгээрээ ан агнах, ангийн дасгал сургууль хийх, ан агнуурын зан үйлд суралцах дадал хэвшлийн хэлбэртэй болж өгнө. Зурхай дээр долоон шагай буюу ангийн бага сүргийг байрлуулсны дараагаар харваачид хоёр талаас өөр өөрийн зурхай дээр байгаа зээрүүдийг “агнахын” тулд хоёр талаас 3 м орчим зайнаас харвана. Харвах явцад бөгийг оновол хоёр зээр аваад бөгийг буцаан байрлуулна. Зээрийг оновол түүнийгээ авна. 2-3 зээр түүнээс олныг нэг харвалтаар оновол зөвхөн нэг зээрийг агнасанд тооцож бусдыг буцаан тавина. Харвахдаа бөг, зээрийг зөвхөн арагш нь гаргана, хэрэв харвасан зээр, бөг хажуу тийш, эсвэл урагшаа унаж зурхайгаас гарвал оносонд тооцохгүй. Ингэж харвавал алдаж харвалаа ан амьтныг шархдуулж зовоолоо гэж харваачийг зэмлэж цэц сайтай харвахыг шаардана. Харвааны явцад зурхай дээр нэг зээр бөгийн хамт үлдвэл бөгийн аль нэгэн талд үлдсэн зээрийг тэр талд нь бөгтэй нийлүүлэн тавьж харвана. Үүнийг зээр харвааны “холбоонд орох” гэнэ (Зураг 2).




Зураг 2. Холбоонд орсон бөг, зээр

Холбоонд орсон тохиолдолд зөвхөн зээрийг харваж гаргах ёстой. Харвахдаа бөгийг оновол торгууль хүлээж “таван хацад” орно. Хац гэдэг нь галз, халз гэсэн утгатай. Бөгийг ганцааранг үлдээн таван янзаар байрлуулаад харваж гаргана гэсэн үг. Илүү их цэц мэргэ ухаан самбаа шаардана. Эхний удаад бөгийг анх тавьсан байрлалаас нь харваж гаргана. Хоёр дахь удаа бөгийг хойш харуулан тэмээ босгож, гурав дахь удаад бөгийг тэмээ босгон хөндлөн тавьж байгаад тус бүр хоёр, хоёр удаа харваж гаргах дэгтэй. Ингэж бөгийг гурван байрлалаас нийт таван удаа харваж гаргахыг “таван хац” харваа гэнэ. Харин холбоонд орсон үед зээр, бөг

хоёрыг давхар харваж гаргавал “ганц хац” харваа үлдэнэ. Энэ тохиолдолд бөгийг тэмээ босгон хойш харуулж байгаад харвахыг хэлнэ. Хац харвааны дараа тоглолт дуусаж хожил гарна.

“Долоон галз харваа”. Зурхай дээр долоон шагайг тэмээ босгож хойш харуулан цувруулан хооронд нь нэг хуруу зайтайгаар тавьж (Зураг 3) харвахыг “Долоон галз харваа” гэнэ. Долоон шагайг долоон зээр гэнэ. Долоон зээрийг аль нэг талаас нь дэс дараалуулан нэг нэгээр нь ээлжээр харвадаг. Хэрэв алгасаж харвасан тохиолдолд торгууль хүлээж гаргасан зээрээсээ эргүүлэн тавина. Эхний сумаар гол дундах зээрийг оновол торгууль хүлээхгүй. Харвааны явцад зээрийг хооронд нь шахаж нийлүүлэхгүй, анх байсан байранд нь байлгаж харваж дуусгана. Долоон зээрийг түрүүлж харваж дуусгасан тал нь хожлоо авна.



Зураг 3. Долоон галз (халз) харвааны өрөг

“Багц харваа”. Долоон шагайгаа бөөгнөрүүлэн атгаж зурхайн гол дунд тавиад харвахыг “багц харваа” гэнэ. Харвах явцад зээр хойшоо гарвал тооцно, харин урагшаа эсвэл хажуу тийш гарвал буцаан тавина. Харвах явцад зээр зурхайн тавцан дээрээс уналгүй тарж байрлаж болно. Ийм тохиолдолд зээрийг хөдөлгөлгүйгээр тус бүрд харваж дуусгана. Өөрийн зурхай дээр байгаа долоон зээрийг түрүүлж харваж дууссан нь хожлоо авна. Алтайн урианхайн шагайн харвааны дээрх гурван төрлийн алинд нь ч сайн харваач нэг удаа таван сумаар онч мэргэн харваж зээрийг дуусган хожил авах бололцоотой байдаг байна. Шагайн харвааны үед уухай гэж байхгүй. Харин шагайн харвааны эхэнд шагайн ерөөл хэлдэг байжээ (Хавсралт 1).

Алтайн монгол урианхайчуудын энэхүү шагай харваа нь Алтайн тува урианхайчууд төдийгүй Тагнын тувачуудад мөн адил уламжлагджээ. Тухайлбал, Алтайн тува урианхайчуудын шагайн тоглоомын дүрэм нь шагайг алган дээрээ тавьж байгаад харвана. Зургаан тохой газраас харвана. Шагай харвахад 7 шагайг

хоорондоо 3 хуруу зайтай өрж тавина. Голын шагайг босоо хэлбэртэй тавих ба “бэрс” гэж нэрлэнэ. Хоёр талын гурав гурван шагайг “зээр” гэж нэрлэнэ. Тоглохдоо хоёр тал болж тоглоно. Хоёр тал адилхан долоо долоон шагай өрнө. Долоон сумаар (шагайгаар) харвана. Голын бэрсийг онож унагавал хоёр талын захын хоёр зээрийг авна. Дахиад оновол мөн хоёр талын, гурав оновол дахиад хоёр талын зээрийг авч дуусна. Голын бэрсийг онохгүй хажуугийн зээрийг оновол зээрээ дангаар нь авна. Бэрс ганцаараа үлдсэн тохиолдолд нар зөв тойруулж 4 талаас нь 4 онож байж дуусна. Бэрс нэг сондгой зээртэй үлдвэл зээр бэрс хоёрын хоорондын зайг нэг шагай багтахаар тавина. Хэрвээ харваад зээрийг оновол торгуулж, бэрсийг дөрвөн талаас нь харвана. Ийм маягаар шагай харваан үргэлжилж зээрээ харваж дуусгасан тал хожино (Баатархүү 2008, 55).

Тагнын тувачууд “кажык адары” буюу “шагай харвах” гэж нэрлэнэ. Энэ тоглоомонд 2 модон самбар орно. Харвах шагай (сум)-аа “ок” гэж нэрлэнэ. Харвах шагай нь хоёр талд тус тус найм, найман шагай байдаг бөгөөд “ан” гэж нэрлэнэ. Тэр 2 самбар нь нэг нь ангуудаа байрлуулах ба харвахад хэрэгтэй. Найман ангийн дотор гол анг “Бүгэ” гэж нэрлэдэг. Талбайн голд байрлуулна. Тэрийг бусад ангуудаас ялгахын тулд том шагай байдаг. Жирийн ангуудаа бүгег тойруулж тавина. Ок-оор талбай дээр тавьсан анг харвана. Харвахад модон хашлага байна. Түүний нэрийг “кажылга” гэдэг. Энэ тоглоомыг 2 буюу 4 хүн тоглоно. Харвах зай нь 7 юмуу 9 дугай (тохой) байна. Хэн эхлэхээ шодно. Хэрэв бүгег оновол 4 шагай авна. Хэрэв энгийн анг оновол нэгийг л авна. Тагнын тувачууд 4 хувилбараар харвадаг. Дөрөвдүгээрх нь гараар шидэж харвадаг (Иргит Самбуу 1978, 83-88). Монголчуудад энэ тоглоом байдаг ба бүгег ноён, анг бол цэрэг гэж нэрлэдэг (Потанин 1881, 119) гэж Потанин тэмлэглэжээ.

Ийнхүү Алтайн монгол болон тува урианхайчууд, Тагнын урианхайчууд (тува)-ын дунд хадгалагдан үлдсэн шагайн харвааны дэг, зан үйлээс харвал хүүхэд залуусыг багаас нь ан амьтныг зүй зохистой агнах (манлай анг агнахгүй байх, амьтныг зовоохгүй байх, хэрэгцээнээсээ илүүт агнахгүй байх гэхчлэн) соёлыг төлөвшүүлэхэд голлон анхаарч байсан нь илт байна.

Урианхай сурын харваа. Алтайн урианхайчууд (Алтайн монгол болон тува урианхайчуудыг хамтад нь өгүүлж байгаа) хаврын тэргүүн сарын шинийн гуравнаас эхлэн бүтэн сарын туршид сур харвадаг. Эдүгээ Монгол оронд халх, буриад, урианхайн гэсэн гурван төрөл сурын харваа уламжлагдан ирсэн бөгөөд дээрх харвааны гурван төрлөөс эртний язгуур шинжээ илүүтэй хадгалж ирсэн нь урианхай сурын харваа юм.

Урианхайн сур харваа хэрхэн бий болсонтой холбоотой нэгэн домогт “Чингис хаан алс хол газарт хийсэн аян дайнаа дуусган эх нутгийнхаа зүг хүлгийн жолоо залан ирж явах зуураа өвс ус тэгш сайхан “Сундайлин” гэдэг газарт саатан хол замын алжаалаа тайлан суухдаа өөрийн итгэлт есөн өрлөгийн нэг урианханы Зэлмэ жанжинг дуудан – миний шалгарсан эрэлхэг дайчин эрс болон хүлэг морьдыг амрах арга ол гэжээ. Зэлмэ жанжин удаан бодсоны эцэст нэгэн арга олж гэнэ. Тэрээр бүх морьдын чөдөр тушааг тайлан ташаанд нь нуман тамга дарж

“Бутын өвс идэж булагнаж яв

Давын өвс идэж далагнаж яв” гэж суллан тавиад цэрэг эрсийн сумны зэвийг

бораагаар (болцуу) сольж, морины чөдөр, тушаа, хазаар, ногт зэргийг бөөрөнхийлөн зангидаж тусгай талбай засан түүн дотроо жагсаан өрж харван өрсөлдөх тоглоомыг тоглуулжээ. Тэр тоглоом Чингис хаанд ихэд таалагдаж тэр цагаас хойш урианхайн сурын харваа үүссэн” (Ганболд, Амгалан 2001, 73-90) хэмээн өгүүлдэг. Энэхүү домогт өгүүлэгдэж байгаа хэд хэдэн бодит зүйл эдүгээ Алтайн урианхайн сурын харваанд уламжлагдан ирсэн байдаг. Эдүгээ тэд морины чөдөр, цулбуур, ногт зэргийг бөөрөнхийлөн зангидаж Алтайн монгол урианхайчууд “чих”, тува урианхайчууд “кулак” гэдэг ба энэ нь монголоор мөн л “чих” хэмээн нэрийдэн харван тоглож байна. Мөн монголын олон ястнууд дотроос эдүгээ малын нуман тамга хэрэглэж буй нь зөвхөн Алтайн монгол урианхай болон тува урианхайчууд болно.

Урианхай сурын харвааг “газрын” болон “мөсний” харваа гэж хоёр ангилдаг ба харин дүрмийн хувьд төдийлөн ялгаагүй байдаг.

Нэг өдрийн харвааг нэг айл даан явуулдаг. Өөрөөр хэлбэл, айлууд сур харваачдыг урьж харвуулах ба сурын талбай засах, харваачдыг цайлж хооллох, харваанд түрүүлэгсдийг шагнаж урамшуулах, унаа морьдын өвс тэжээлийг бэлтгэх зэрэг бүхий л зардлыг сур харвуулж буй айл хариуцдаг. Сур харвуулах нь тухайн айлын тухайн жилийн аз хийморийг авчирч, муу муухайг хөөн зайлуулдаг хэмээн үздэг тул сурыг аль болох өөрийн хотонд харвуулахыг эрмэлздэг. Өөрөөр хэлбэл, сур харвуулсан айлд тэр жилдээ гай барзад тохиолдохгүй гэдэгт итгэдэг.

Харваанд эвэр ишт нум болон модон хавчаахай хэрэглэж иржээ. Модон хавчаахай нумыг бургас болон хар мод, хус зэргээр хийнэ. Бургас нь татах, тавихад харимхай чанар сайтай байдаг. Яргүй, салхитай газрын хар модыг сүүдэрт хатааж зүсэж хийх, мөн аянга буусан хар модны усан цагаан хальстай хэсгээр хийдэг. Хавчаахай хийх модоо холтостой нь нар салхи үзүүлэхгүй сүүдэр газар нэг жил орчим хатаана. Дараа нь нимгэн зузааныг нь тааруулж зорно. Голыг арай зузаан, хоёр үзүүр талыг нимгэн зэрэг эвхрэхээр зорно. Хар модоор хийсэн нум тийрэлт сайтай ч хатуу учраас хүйтэнд хөрч хугардаг муу талтай. Ийм нумыг хүйтэн өдөр гэнэт татвал хугардаг тул аяар зугуухан татна. Хавчаахайг голчлон 2.20 метр урт хэмжээтэй хийдэг. Үүнээс богино хийвэл хугардаг. Эвэр нумыг хийхдээ хатуу мод, янгирын эврийг зүсэж, бугын зооны шөрмөсөөр нааж хийдэг байна. Хөвчийг гол төлөв үхрийн арьсаар, сүүлийн үед мяндсаар хийх болжээ.

Сумыг голчлон бургасаар хийж, булцууг хусаар, мөн бугын эврээр хийж тасын өдөөр өдөлнө. Булцууг Алтайн урианхайчууд болцуу, бораа хэмээн нэрлэдэг ба сумны их биеийг мөсгөө гэдэг.

Урианхайн сурын харваанд онох байг нь “сур” буюу “чих” гэнэ. Тува урианхайчууд “кулак” буюу “чих” гэдэг. Ингэхдээ талбайд тавьсан бүх байг сур, хувь харваач харван авч байгаа сурыг чих буюу кулак гэж ялган нэрлэдэг. Хүн болгон хоёр бөөрөнхий суртай байна. Сурыг үхрийн нарийн зүссэн сураар бөөрөнхийлж зангидаж хийдэг. Бусад малын ширээр сур хийхийг төдийлөн таашаадаггүй аж. Тухайлбал, тэмээний ширээр сур хийхийг хатуу цээрлэдэг. Тэмээний ширээр үдээр хийдэг учир үдээр тавьж харваж болохгүй, сур талбайгаас гардаггүй, сум хугарах аюултай гэж үздэг байна. Мөн адууны арьсаар хийсэн сураар чих зангидахгүй, учир нь хүлэг мориныхоо арьс ширийг харван наадах, бай болгох нь морио харвасантай

адил хэрэг гэж цээрлэнэ. Сурыг сум оноход задарч салбарахгүйгээр сайн зангидсан байх ёстой. Хэрэв сур задарвал “хэний гэдэс цуваад байна” хэмээн эзнийг нь олж дахин эвхүүлдэг учир эзэн хүнд ихэд ичгүүртэй байдаг аж.

Нэг харваач хоёр чих бэлтгэн оролцдог. Өөрөөр хэлбэл, харваач өөрийн хоёр чихийг дэнчин болгон сур харваанд тавьж байна гэсэн утгатай. Иймд харваач өөрийн тавьсан хоёр чихийг зүслэн харваж заавал авахыг эрмэлздэг. Ер нь харваач харваа бүрдээ дор хаяж хоёр чих заавал харван авах ёстой. Эс тэгвээс зохих шийтгэл хүлээн “хамба суух” буюу тувачууд “хамбарлаа” хэмээн торгуулдаг. Энэ нь ямархуу шийтгэл болох тухай хойно хожил тооцох журамд өгүүлнэ.

Урианхай харваанд эрт үед хүн бүр гурван чих бэлддэг байжээ. Түүний нэгийг чөдрөөр зангидаж “чөдөр”, нөгөөг цулбуураар зангидаж “хом” гэж нэрлэнэ. Гурав дахийг нарийн сураар арай бага овортой зангидаж “даанж” гэж нэрлэнэ. Ийнхүү хүн бүр гурван чих тавьж байсан үед хүн бүрийн даанжийг илгэн уутанд хийж чөдөр, хом хоёрыг өрж харвадаг байсан байна (Наянтай 1993, 61-64). Хожим нь хом гэдэг нь мартагдан арилж зөвхөн чөдөр, даанж гэсэн хоёр чих бэлтгэдэг болжээ. Чөдөр, цулбуур зэргээр сур бэлтгэдэг байсан нь эр хүний байнга эдэлж хэрэглэдэг морь унааны эдлэл хэрэглэл учир бэлэн харван наадахад дөхөмтэй аж. Дээр өгүүлсэн даанж нэртэй сурыг эмээлийн ганзагаар хийсэн бололтой байдаг. Учир нь сурчид сурын харвааны ахлагч гурав дахь сумаа тавихад “ганзага” хэмээн уухайлдаг нь үүнийг илэрхийлэх мэт санагдана (Ганболд, Амгалан 2001, 73-90).

Харваа эхлэхээс өмнө сур харвах талбайг зассан байдаг. Цэвэрлэж зассан талбайн голд хоорондоо 5 нумын зайтай (нэг нум нь 1.5-2.5 м) хоёр талд цас, шороо, өтөг бууц зэргийг цувуулан асгаж хоёр талаас нь налуулан дарж гурвалжин хэлбэрт оруулан дээд талд нь шовхдуу орой гаргадаг. Үүнийг Алтайн урианхайчууд “өтвөг”, тэр дундаа Зүүн амбаны урианхай нар “өтвөөг” гэж уртаар нэрлэдэг. Харин тувачууд “өдүмэг”, “өтвэг”, “өтөг” гэхчлэн нэрлэдэг. Сур давж гарах өтвөгийг “урд өтвөг”, харин давж орох өтвөгийг “хойд өтвөг” гэдэг. Хоёр өтвөгийн хоорондох зайг сайтар цэвэрлэж засна. Хоёр талд зассан өтвөгийн голоор аль алианаас нь тэнцүү зайд сураа буюу чихийг цувуулан өрж харвана. Сур өрөх газрыг “хэвэр” гэдэг. Нэг талын өтвөгөөс өрсөн сур 2.5 нумын зайтай байрлана. Өтвөгийн өндөр 15-20 см байх бөгөөд харваачдад өтвөгийн дотор өрсөн сур харагдаж байх ёстой. Харин өтвөгийн урт нь харваанд оролцогчдын тоо буюу тэдний өрсөн сур (чих)-ны тооноос хамаарна. Олон харваач оролцон олон чих өрвөл өтвөг төдий чинээ урт болно.

Өтвөг тус бүрийн хажуу талд голлуулан өрсөн сурын захаас 1.5-2 нумын зайтай газар буюу хэвэрийн хоёр талд харваж оносон чихийг хийх цас буюу шороогоор зассан байрыг “гал” эсвэл “хайс”, Зүүн амбаны урианхайд “гэр” хэмээн нэрлэдэг. Хайсны хойд талд залгаж бас нэгэн жижиг хайс бэлдэнэ. Үүнийг дараа дарах гэж нэрлэх бөгөөд түүнд хүний тооноос илүү гарсан чихийг булж хадгалдаг.

Сур харвахдаа өтвөгийн захаас 25-30 нумын зайнаас харвана. Харвах явцад талбайд 3 сур үлдэхэд 15 нумын газраас, 2 сур үлдэхэд 13 нумын газраас, 1 сур үлдэхэд 11 нумын газраас харвана. Ингэж зайгаа ойртуулан харвахыг “саалтанд орлоо” гэж ярилцдаг. Саалтанд заавал магнай харваач эхэлж харвадаг. Саалтын газрыг урьдчилан шороо асган тэмдэглэсэн байдаг.

Урианхайн сурын харваанд хүний тоо, нас харгалзахгүйгээр харвадаг. Сур харвааг хэнийд харвахыг урьдчилан зарлах ба харваанд оролцохоор ирсэн харваачдыг хоёр хэсэг болгон хүч тэнцүү багт хуваана. Үүний дараа багийн ахлагчийг сонгох ба “магнай” гэж нэрлэдэг. Тува урианхайчууд “Магнайчы” гэдэг.

Тува урианхайчууд цагаан сарын битүүний өдөр нумтай айлаас нумыг нь хамгийн өндөр настай айлд аваачиж залдаг. Тэр өндөр настныд нум шинийн гурван буюу харвах өдөр хүртэл байдаг. Сурчид цугларч багаа бүрдүүлсний дараа гэрийн эзэн тэдний дотроос хамгийн ахмад харваачид нум сумыг сүүгээр мялаан хадаг уясны дараагаар өргөн барьж, сум тавин ерөөл айлтгахыг хүсдэг. Ахмад харваач нумыг авч гэрийн тооноор гурван сумыг гадагш харван гаргадаг. Нэг хотонд хэдэн айл байна, айл бүрийн тооноор харвадаг. Эхний сумыг харвахдаа:

“Эрээн цоохор нумын тийрэлтээр
Элдэв муу тань арилах болтугай”

Хоёр дахь сумыг харвахдаа:

“Хатуу хар нумын эвшээлтээр
Хамаг муу тань арилах болтугай”

Гурав дахь сумыг харвахдаа:

“Хүчит хүрэн нумын эвшээлтээр
Хар болсон юм бүхэн
Хатуугүй зөөлөн болог
Хир болсон юс бүхэн

Хиргүй тунгалаг болтугай” (Пунцагдорж 1992, 20) гэж ерөөлийн үг хэлдэг байна. Энэ үед гэрт байгаа хүмүүс тооноор сур харвах бүрт нь “тэр ерөөл бат орших болтугай” хэмээн хэлцгээдэг. Дараа нь харваачид нумнаас адис авч харвааг эхлүүлэхээр гардаг. Харвахдаа хоёр багийн хүмүүс ээлжилж харвадаг. Харваанд оролцох хүний тоог хязгаарладаггүй бөгөөд харваа эхэлснээс хойш ирсэн хүнийг ч оролцуулдаг байна. Баг бүрдэж бэлэн болсны дараа сур өрөгчийн хормойд түүний талын харваачид чихнүүдээ хийнэ. Үүний дараа чихнүүдийг өрнө.

Сурын уухай нь онооны уухай, агираа уухай, өрсөлдөгч талын уухай гэсэн гурван янз байна. Хамгийн эхлээд баруун талын харваач харвана. Үүнийг “онь авах” хэмээдэг. Харин дараагийн өрөгт хожсон эсэхийг үл харгалзан зүүн талын ахлаач харвах гэхчлэн өрөг тус бүрд онь хоёр талд ээлжлэн шилжиж байх ёстой. Ахлагч нар эхний сумаа тавихад “магнай” хэмээн уухайлдаг. Энэ нь халзыг харваж оноорой гэсэн уухай юм. Халз гэдэг нь чихнүүдийн дотроос цэвэрхэн үзэмж сайтай зангидсан, сум оноход гарахааргүй, голлуулж өрсөн, чөдөр буюу суран чихийг хэлдэг. Халзнаас хоёр тийш бусад сурыг өрдөг. Хоёр дахь сумыг тавихад “тэгнээ” гэж уухайлдаг. Тэгнээ гэж халзын дараагийн буюу халзын дэргэд байгаа сурыг хэлдэг. Гурав дахь сумыг тавихдаа “танзага” хэмээн уухайлна. Энэ уухайд хэвэрт өрсөн аль ч чихийг оносон болно. Ийнхүү ахлагч нарын тавьсан сум оносон, эс оносон ч дээрх гурван уухайгаар уухайлдаг. Ахлагчийн дараагаар бусад харваачид сум тавих үед өөрийн талынхан нь “эдэк эдек” буюу “хормойл хормойл” гэж уухайлна. Хормойл хормойл гэдэг нь харвасан сурыг бид хормойлоход бэлэн байна, сайн оноорой гэсэн санаа юм. Хамгийн бага залуу сурчин оносон сурыг хормойлж өтвөгийн захад байрлах жижиг хайсанд хийдэг.

Тува урианхайчууд эсрэг талын харваачийг харвахад “жилэн таш, жилэн таш” гэж уухайлдаг. Харин Алтайн монгол урианхайчууд “гилэн тош, хууг хууг, сур заагтай суман гажигтай” гэх мэтээр уухайлдаг. Үүнийг “агираа” уухай гэдэг. Гилэн тош гэсэн агираа уухайг Булган голын урианхайчууд их хийдэг бөгөөд мөсний харвааны үед сум сурыг онолгүй гялгар мөсөнд халтиран гялс хийгээд тош гэсэн чимээ гаргаад одлоо гэсэн утгатай байдаг.

Мөсний харваанд хүн бүр өөрийн хоёр сумаар, газрын харваанд гурван сумаар дараалан харвана. Харваж оносон оноог доорх нөхцөлд тооцно.

Харвасан сум нь талбайн голд байгаа сурыг онож цаад талын өтвөгийг даван гарсан тохиолдолд харваач нэг чихээ авсанд тооцно. Хэрвээ сум өөрийн талын өтвөгийг шүргэсэн бол сурыг гаргасан ч тооцохгүй. Үүнийг “доор туслаа” гэдэг. Мөн сум өтвөгийн дунд байгаа сурыг оносон ч сур нь цаашаа өтвөгийг давж гараагүй бол мөн л тооцохгүй. Үүнийг “амьдаар нь барилаа” гэдэг.

Оносон сур эсрэг талын өтвөгийн дээр нь гарч аль нэг тийшээ уналгүй тогтох тохиолдол байдаг. Ийм тохиолдолд өтвөгийн дээд ирмэгийн дагуу сум, нумны хөвчний аль нэгийг тавьж үзээд аль талд сурын ихэнх байна тэр тал авна. Цаад талд их байвал чихээ авсанд тооцно, наад талд их байвал “амьдаар нь барилаа” хэмээн тооцохгүй. Харин чихийг чөдрөөр хийсэн тохиолдолд чагт нь гадагш харж унасан байвал чихийг давсанд тооцон авдаг байна. Урианхай сурын онцлог бол сур буюу чихийг оносон тоолонд оноо авахгүй, харин өтвөгийг цэвэр давуулж гаргасан тохиолдолд тооцдог. Өөрөөр хэлбэл, сурыг онолоо гэхгүй, гаргалаа гэж ярьдаг.

Зарим тохиолдолд сур хоёр, гурваараа эсвэл түүнээс олноороо өтвөгийг давах тохиолдол байдаг. Ийм нөхцөлд 4 сурнаас гурвыг, 3 сурнаас хоёрыг, 2 сурнаас нэгийг гэхчлэн нэгийг хасан авч хайсандаа хийнэ. Мөн оносон сур өнхөрч аль нэг талын хайсанд орвол аль ч талын хайсанд орсон хамаагүй тэр талынх болно. Онож гаргасан сурыг хоёр талын хамгийн залуу сурчин хормойлж хайсандаа хийдэг.

Урианхайн мөсний сур харваанд хожил авахын тулд өөрсдийн талын тавьсан сурыг харваж дуусчихаад эсрэг багийнхаа сурнаас илүүчилж авахыг эрмэлзэнэ. Хэдэн сур илүү авснаар хожил тооцохоо хоёр багийн ахлагч урьдаар тохиролцоно. Зарим тохиолдолд хоёр баг тэнцүүхэн өрсөлдөж төдий тооны сур илүү авсан нь хожно гэсэн тоондоо хүрэхгүй байж болно. Ийм тохиолдолд сураа хэдэн ч удаа өрж, хэд хэдэн оноогоор харвах явдал бий.

Харин урианхайн газрын харваанд хожил тооцох журам арай өвөрмөц байдаг. Энэ нөхцөлд өрөг тус бүрд хожил тооцно. Өрөг дууссаны дараа хайсан дахь сурыг хоёр хоёроор тоолж сур өрөгчийн хормойд хийдэг. Хэрэв хүний тооноос сур илүү гарсан байвал түүнийг өрдөггүй, дараагийн хайсанд булж дардаг. Багийн хүний тооноос сур дутсан бол чөдрөө тоолно. Чөдөр нь хоёр сумтай, даанж нэг сумтай тэнцэнэ. Тухайлбал, баг бүр 20 харваачтай байсан бол хожигдсон тал 34 сур авснаас 24 чөдөр байвал ээлж тус бүрт тэр талын 19 харваач 3 сумаа харвах, нэг харваач 1 сум харвах эрхтэй үлдэнэ. Нөгөө хожсон тал 6 сурыг дарна. Дараагийн өрөгт хожигдсон тал дахин хожигдох буюу 30 сур авсны 15 нь чөдөр байвал зөвхөн 15 харваач ээлж тус бүрдээ 3 сумаа харвах эрхтэй үлдэнэ. Харин 5 харваач нэг ч сум тавих эрхгүй үлдэнэ. Ийм сум тавих эрхгүй болсон харваачийг “хамба суулаа” (камба суулаа), “камбарлаа” гэж хэлдэг. Энэ нь нэлээд хатуухан шийтгэлтэй бөгөөд

камбарсан харваачийг нүцгэн бөгсөөр нь хатуу газар, мөсөн дээр суулгаж шийтгэнэ. Харин тувачууд 3 сум тавьж 2 сур онохгүй бол “хамбарлаа” торгож нэг сумыг нь хасаж, “хоёр сумт” хэмээн шоглодог. Мөн зарим тохиолдолд харваж дуусаад сураа тоолж хүнийхээ тоонд хоёроор хуваан илүү гарсан тал нь хожих тохиолдол ч байдаг. Дээрх хожил тооцох журам нь Алтайн тува урианхайчууд хийгээд, Алтайн монгол урианхайчуудын сурын харваанд мөрддөг журам юм.

БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай аймгийн урианхайчуудын сурын харвааны хожил тооцох журам арай өөр байна. Харваач бүр 3 сур авч ирээд хоёрыг нь өрж, нэгийг нь арьсан тулманд хийж хадгалдаг ба тийн хадгалсан сураа “даанж” гэдэг. Тухайн өрөгт хүн тус бүр хоёр чихээ харваж эс чадваас дутуу чихээ нөгөө арьсан туламнаасаа авч нөхнө. Тулманд хадгалж байгаа даанж дууссаны дараа чихээ харваж чадахгүй бол багийн гишүүд сүүлчээсээ эхлэн дахин хоёр сумаар харваж эхэлнэ. Ийн хоёр сумаар харвах харваачийн тоо 5 хүрсэн үед хоёр чихээ авч чадаагүй, эсвэл нэг ч чих аваагүй харваачийг камбад суулгадаг байна. Мөн сурын хожлыг даанжаар ба хом чөдрөөр гаргах хоёр арга бас бий. Даанжаар хожил тооцохдоо хэдэн өдрийн турш харваж оносон сурын тоог илүүдсэн дутсанаар нь тооцон илүү авсан нь хожно. Хом чөдрөөр хожил тооцохдоо тухайн өдрийн сүүлийн өрөгт бүх сурыг өрж тавих буюу эсвэл харваач бүр хоёр чих тавьж харваад аль олон сур харваж авсан баг өдрийн хожлыг авдаг байна (Наянтай 1993, 64). Сурын харвааны явцад харваач бүрийн өрөг тус бүрд оносон сурын тоог тэмдэглэж хамгийн олон сур харвасан харваачийг шалгаруулан харваа дааж байгаа айл шагнаж урамшуулна.

Урианхайн сур харваа нь халх, буриад сурын адил цуваа харваа харвадаггүй, нэг зурхайд харвах хүний тоог хязгаарладаггүй, өрсөн сурыг зөвхөн онож задалснаар оноо тооцдоггүй, харвах сур нь харьцангуй хүнд, харвааны зай ойрхон, сумны болцуу нь бахим, тогтсон нарийн дэг ёс, зан үйлийн дагуу харвадаг зэрэг онцлогтой бөгөөд монголчуудын харвааны хөгжлийн нэлээд эрт үеийн дүр төрхийг харуулж байна.

Урианхай сурын харваа нь Алтайн монгол болон тува урианхайчуудын түүх уламжлалыг тодруулах чухал эх сурвалж юм. Өмнө өгүүлсэнчлэн, урианхай сурын харвааны үүслийг Чингис хааны түүхэн үйл явдалтай холбон домоглодог. Энэ нь урианхай сурын харваа болон малын нуман тамга хэрэглэж буй ард түмэн нь монголын олон ястнууд дотроос зөвхөн Алтайн монгол урианхай ба Алтайн тува урианхайчууд юм.

Түүхэн үйл явдал ч дээрх аман домгийг нотлох мэт. Туулай жил буюу 1219 оны хавар Чингис хаан Их хуралдай хуралдуулж Хорезмыг дайлах асуудлыг гол болгон хэлэлцүүлээд, дайны бэлтгэл хангагдсан, их цэргийн явах чиглэл зам тогтоогдсон, дайн хийх төлөвлөгөө сайн боловсрогдсон, их цэргийг Чингис хаан өөрийн биеэр удирдах нь зүйтэй гэдэг шийдвэр Их хуралдайгаас гаргажээ (Далай 2006, 166). Энэ тухай “Монголын Нууц Товчоо”-ны § 257 зүйлд “Туулай жил (1219) Сартуул иргэнд Арайгаар (Б.Б Алтай) даван морилоход Чингис хаан хатдаас Хулан хатныг аван аялруун. Дүү нараас Отчигин ноёныг Их Аурагт түшиж [үлдээн] морилов. Зэбийг манлай [болгон] илгээв. Зэбийн араас Сүбээдэйг илгээв. Сүбээдэйн араас Тохучарыг илгээв...” (Цэрэнсодном 2000, 172) гэхчлэн өгүүлжээ. 1219 оны зун цаг эхэлж байхад Чингисийн удирдсан их цэрэг Эрчис мөрөн хүрч хороолон буугаад

зуны цагийг тэнд өнгөрүүлж цэрэг морьдоо амраан, бүх цэргээ бөөгнөрүүлэн сургуулилж, цэргийн зохион байгуулалтаа шалган цэгцэлжээ (Далай 2006, 168).

Улмаар Хорезмийн дайныг дуусгаж, Чингис хаан 1223 оноос нутаг буцах бэлтгэл хийж, Куланбашид зуныг өнгөрөөгөөд 1224 оны хавар нутаг буцах замдаа зуны дэлгэр цагийг Эрчис мөрний үзэсгэлэнт эрэгт (Хар Эрчис) өнгөрөөжээ. Тэр үед нэгэн түүхэн үйл явдал болсон билээ. Эрчис мөрний эх орчим Буга Сочигай гэдэг газар Хорезмыг дайлсан дайны ялалтыг тэмдэглэж их найр хурим хийжээ. Тэр найрын үеэр Чингис хааны дүү Хасарын хоёрдугаар хүү Есөнмөнх мэргэн 335 алд газар харваж оносон гэдэг. Түүний дурсгалд зориулж монгол бичиг сийлсэн чулуун хөшөө босгосныг “Есүнгээ ноёны гэрэлт хөшөө” буюу “Чингисийн чулууны бичиг” гэдэг. Монгол нутгаас нь хоёр ач болох Тулуйн хоёр хүү 10 настай Хубилай, 6 настай Хүлэг нар угтан ирж уулзаад Их Монгол улсынхаа байдлыг танилцуулсан гэж сурвалжид тэмдэглэжээ. Ингээд тэндээс хөдөлж 1225 оны 2-р сарын сүүлчээр Туулын хөвөөнд буй ордондоо Чингис хаан 64 нас сүүдэртэй морилон ирсэн түүхтэй (Далай 2006, 178). Энэ тухай “Монголын Нууц товчоо”-ны § 264 зүйлд “Сартуул иргэнд [Чингис хаан] долоон жил явж тэнд Жалайрдай Балааг бүхүйд Бала Шин мөрнийг гэтэлж Жалалдин султан, Хан Мэлиг хоёрыг алдаж, Хиндүсийн дунд хүртэл эрж ядаад буцаж Хиндүсийн хязгаар иргэнийг [эзлэн] дагуулаад олон тэмээ, олон сэрхийг [олзолж] аваад иржээ. Тэнд Чингис хаан харих зуур Эртис (Эрчис) [мөрөнд] зусаж долдугаар он тахиа жилийн (1225) намар Туулын Хар шугуйн ордонд буув” (Цэрэнсодном 2000, 175) хэмээн өгүүлжээ.

Түүнчлэн эрдэмтдийн судлан үзсэнээр аливаа ард түмний угсаа гарвалыг мөшгин судлахад “хамгийн эртний ихээхэн үнэ цэнтэй цорын ганц бичигдмэл гэж хэлж болох эх сурвалж нь тамга болдог аж” (Сымченко 1965, 3). Тиймээс малын тамга нь угсаатны түүхэн уламжлалыг илүү бат хадгалдаг, тэдний угсаа-түүхийг судлах гол чухал хэрэглэгдэхүүн болдог билээ. Манай нэрт түүхч Х.Пэрлээ тамгыг “... олон угсаатан ард түмний харилцан холбогдох харь элэгтэн, халуун садангаа ялган мэдэх нэгэн чухал бэлгэ тэмдэг” хэмээн үнэлсэн бөгөөд монголчуудын гарлыг тамгаар хөөн судлах талаар анхны дорвитой бүтээл туурвисан билээ. Өөрөөр хэлбэл, Алтайн тува урианхайчууд болон Алтайн монгол урианхайчууд зөвхөн нуман тамга хэрэглэж ирсэн уламжлалтай ба Зүүн гарын Цагаан соён, Хар соёны хошууныхан адууны зүүн талд, Баруун гарын Хөх мончоогын хошууныхан адууны баруун талд нуман тамгаа дарах уламжлалаа эдүгээ хүртэл хадгалсаар байна.

Дашрамд өгүүлэхэд, эдүгээ Баянхонгор аймгийн халхчуудын дунд өвлөгдөн уламжлагдсан “Дөчин нэг харвах” гэдэг шагайн харваа нь зарим талаараа урианхай сурын харваа, урианхайн шагайн харваатай төстэй зүйл ажиглагдана. “Дөчин нэг харвах” гэдэг шагайн харваанд нийт 4 хүн тоглоно. Нэг талдаа 41 шагай, нөгөө талдаа 41 шагай хавтгай дөрвөлжин модон дээр овоолж өрж тавина. Нийтдээ 82 шагайгаар тоглоно. Монгол гэр дотроо хоёр талд зурхайгаа засч, зурхайнхаа хоёр талд хоёр, хоёр харваач сууна. Хоёр хүний дунд хавтгай модон дээр шагайгаа овоолж тавина. Сум нь тэмээний чөмөг, шагайг хөрөөдөж хийсэн том сум байна. Эхний хүн харваад бут үсэргээд модноос унасныг нь авна. Модноос унаагүй бол авахгүй. Модон дээр үлдсэнийг нь дараагийн хүн харвана. Эхний хүмүүс харваад

бүх шагайг унагаад сүүлийн хүн харвах шагайгүй үлдвэл тэрийг зэмд суулаа гэнэ. Ганц шагай үлдээд тэрийг нь сүүлийн хүн харваад авчих юм бол тэмээ хулгай хийлээ гээд урд нь тэр шагайг нь гаргаад тавина. Тэмээний хулгайч ч гэнэ. Тэгээд зэмд явсан, тэмээ хулгай хийсэн хүндээ жигтэйхэн хоч өгнө. Нийт 82 шагайг бүрэн гаргаж байж л хожлоо шийднэ. Тэмээний чөмгөн сум нь их хүнд, бас том байна. Муухан жижиг сум бол модон дээрх шагай руугаа ороод зогсоно. Шагайгаа дуустал нь харваж хожилцоно. Сайн харвадаг хүмүүс бол дараагийн хүмүүстээ үлдээхгүй л харвана. Аль болох эсрэг талын хүнээ зэмд явуулж хашлага бариулахгүйг хичээнэ шүү. Зэмд гэдэг нь хашлага сум бариулах эрхгүй л болгож байгаа аж (Мөнхтөр 2026, 3).

Энэхүү “Дөчин нэг харвах” шагайн харвааны дүрэмд дөрвөлжин мод буюу зурхай дээрх овоолсон шагайг харваж оноод зурхайгаас гаргавал оносонд тооцох буюу авна. Энэ нь урианхай сурын харвааны чихийг онож өтвөгөөс гаргах дүрэмтэй ижил байна. Сурын харваанд чихийг оноод оногдсон чих нь өтвөгөөс гараагүй тохиолдолд тооцохгүй. Зарим тохиолдолд сур хоёр, гурваараа эсвэл түүнээс олноороо өтвөгийг давах тохиолдол байдаг. Ийм нөхцөлд 4 сурнаас гурвыг, 3 сурнаас хоёрыг, 2 сурнаас нэгийг гэхчлэн нэгийг хасан авч хайсандаа хийнэ. Мөн урианхайн шагайн харваанд харвах явцад зээр хойшоо гарвал тооцно, харин урагшаа эсвэл хажуу тийш гарвал буцаан тавина. Харвах явцад зээр зурхайн тавцан дээрээс уналгүй тарж байрлаж болно. Ийм тохиолдолд зээрийг хөдөлгөлгүйгээр тус бүрд харваж дуусгана. Эндээс үзвэл урианхайн шагайн харваа, сурын харваа, халхын зарим нутаг дахь “Дөчин нэг харвах” зэрэгт ижил төстэй зүйл ажиглагдаж байгаа нь сонирхол татаж байна.

Хэлэлцүүлэг

Монгол угсаатанд сурын халх харваа, буриад хараа, урианхай харваа уламжлагдан үлджээ. Түүнчлэн шагайн харвааны олон төрөл, тухайлбал, халхчуудын дунд хуучны уламжлалт халз харваа, шагайн харвааны тойрмын харваа түгээмэл уламжлагдаад байна. Харин бидний өгүүлэн буй Алтайн урианхайн долоон хошууны буюу монгол болон тува урианхайчуудын дунд шагайн харвааны өвөрмөц төрөл болох зээр харваа уламжлагдсан байна. Монголчуудын сурын харвааны гурван төрлийн нэг болох урианхай сурын харваа нь мөн адил зөвхөн Алтайн долоон хошууны хойч үе болох монгол урианхай болон тува урианхайчуудын дунд уламжлагдан ирсэн өвөрмөц онцлогтой бөгөөд энэ уламжлал одоо ч хэвээр байна.

Дүгнэлт

Эдүгээ Алтайн урианхай хэмээх нэрийн дор монгол болон тува урианхайчууд оршин аж төрж ирсэн бөгөөд тэдний дунд харвах наадгайн эртний төрөл болох “Урианхай сурын харваа”, “Шагайн харваа”-ны өвөрмөц төрлүүд уламжлагджээ. Түүхэн сурвалжийн мэдээнээс үзвэл, урианхай сурын харваа нь Чингис хааны баруунш байлдан дагуулсан түүхэн үйл явдалтай холбогдож байна. Энэ нь зөвхөн Алтайн урианхайчуудын дунд “Урианхай сурын харваа” уламжлагдсантай холбоотой бөгөөд мөн тэдний тунд “нуман тамга” уламжлагдсанаар давхар нотлогдоно. Түүнчлэн монгол угсаатны өргөн дэлгэр нааддаг шагайн харваа нь

халз харваа, зээр харваа, тойрмын харваа гэхчлэн олон төрөлд хуваагдах бөгөөд шагайн харвааны эртний уламжлал болох “Зээр харваа” нь Алтайн урианхайчуудад уламжлагдсан байна.

Ашигласан материалын жагсаалт

- Баатархүү, Б. 2008. *Төв аймгийн Заамар суманд ажилласан угсаатны зүй хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн: Төв аймгийн Заамар суманд амьдарч буй тува Сосорын Хийснаагаас тэмдэглэж авсан мэдээ*. ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн Түүхийн баримт, мэдээллийн төв. 2026.02.15.
- Баатархүү, Б. 2017. *Монгол улсын тувачууд*. Улаанбаатар.
- Баатархүү, Б., Баярсайхан, Б. 2019. “Тувачуудын уламжлалт тоглоом.” *Дэлхийд данслагдсан монгол өв: Монгол наадгайн соёл*. ОУЭШХ-ын эмхэтгэл. I. Улаанбаатар.
- Гагаа, Ч. 2009. *Тува өвгөний дурдатгал*. Улаанбаатар.
- Ганболд, М., Амгалан, Д. 2001. “Алтайн урианхайн сур харвах ёсон.” *Угсаатан судлал XIII*: F10.
- Ганболд, М. 2001. *Алтайн урианхайн уламжлалт шүтлэг*. Улаанбаатар.
- Ганболд, М., Эрдэнэтуяа, Т. 2019. “Алтайн урианхайн шагайн харваа.” *Дэлхийд данслагдсан монгол өв: Монгол наадгайн соёл*. ОУЭШХ-ын эмхэтгэл. I. Улаанбаатар.
- Гантулга, Ц. 1999. *Алтайн урианхайчууд*. Улаанбаатар
- Далай, Ч. 2006. *Их Монгол Улс*. Улаанбаатар.
- Иргит Самбу. 1978. *Тувинские народные игры*. Кызыл.
- Иргит Самбуу. 1992. *Тыва оюннар*. Кызыл.
- Мөнхтөр, Ч. 2026. “Угсаатны зүйн судалгаан дахь шагайн харваатай холбогдох мэдээ ба зарим онцлог төрийн тухай.” *Монголын үндэсний шагайн харваа: түүх, соёл, уламжлал, ирээдүй*. ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Монгол үндэсний шагайн харвааны холбоо хамтран зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар.
- Наянтай, С. 1993. “Алтайн урианхайчуудын сур харвах тухай.” *Үүрийн цолмон (БНХАУ, Үрэмч)*.
- Потанин, Г.Н. 1881. *Очерки Северо-Западной Монголии. Т II*. СПб.
- Пунцагдорж, Б. 1992. *Алтайн урианхайн сурын харваа*. Өлгий.
- Сымченко, Ю.Б. 1965. *Тамги народов Сибири XVIII века*. Москва.
- Цэрэнсодном, Д. 2000. *Монголын Нууц Товчоо эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар*. Улаанбаатар.

Алтайн урианхайн шагайн ерөөл

Зээ

Өдрийн сайныг өнжин хүлээж
Сарын сайныг саатан хүлээж
Цаг учрал бүрдсэн
Чухал сайн өлзийт цагт
Цугларч байсан бид вээр
Төрийн ёсоор төгрөглөн сууж
Түмний ёсоор найрлан сууж
Бэлэг дэмбэрэл зохицсон
Билиг ухаан төгс
Хөгжөөнтэй сайхан шагайн наадмаа
Хөгжөөн эхлэх журамтай билээ
Хангарьд шувуун
Хад чулуун дээр
Өндөглөж өсдөг боловч
Жигүүр өд нь гүйцэхийн цагт
Хан их огторгуйдаа
Халин халин нисдэг л
Хайрлаж өсгөсөн хүүхдүүд минь
Хэдий олон боловч
Хамаг олны дундаас
Онцлон гарах шагайчин
Нэгэн хоёр л байдаг л
Шагайн гэгч сайхан наадам
Шүүгээд ирэхэд хортой ч наадам
Дан давхар ялгаатай наадам
Даяар олонд талтай ч наадам
Түүх холбох журамтай наадам
Тогтоож харвах ёстой наадам
Бэлтгээ төлөгийн үнэтэй наадам
Шоо мөрийн тостой наадам
Атгах, няслах, уралдах, мөрийцэх
Учиртай ч наадам
Буга жиргээ шиг
Буянтай ч наадам
Малын шагай машид эрдэнэ
Манай сайхан наадмын эрдэнэ
Хонин шагай ховор эрдэнэ
Хотол даяараа наадмын эрдэнэ
Тэгш тал нь морин эрдэнэ
Хондлой тал нь хонин эрдэнэ
Хотгор тал нь ямаан эрдэнэ

Босоо тал нь морин эрдэнэ
Бөгтөрөгтөй тал нь тэмээн эрдэнэ
Уран зогсгол нь онгон эрдэнэ
Ухаан бүлээсгэх тансаг
Уран санаат наадам билээ
Алаг эрээн шагай чинь талбай дүүрэн
Адуу мал чинь тал дүүрэн
Эрээн шагай чинь ширдэг дүүрэн
Эрдэнэ сүрэг чинь энгэр дүүрэн
Даяар монголын бэлгэт наадам
Даян бүгдийн сайхан наадам
Наадсан газарт нь нар гарч
Наадуулсан эзэд нь зуу насалтугай